

10 **Өглөөний Сонин**

Монгол мэдээ

Тэртээ 2006 онд "Өглөөний сонин" хэмээх их айл үүдээ нээснээс хойш 10 жилийн ардаа орхижээ. "Өдөр тутмын шилдэг сонин" өргөмжлөлийг гурвантаа хүртэж, Сонины холбооноос таван ч удаа "Топ-5" сонинор шалгарч байсан Монголын өдөр

тутмын анхдагч чөлөөт хэвлэл "Өглөөний сонин" өөрийн өнгө төрх, нийтлэлийн бодлогоороо эрс ялгардаг билээ. Монгол Улсад ардчилсан чөлөөт сэтгүүл зүй үүсч хөгжихөд үнэтэй хувь нэмэр оруулсан, хараат бус дөрөв дэх засаглалыг

хөгжүүлэхэд түүчээ болж яваа "Өглөөний сонин"-ы үе үеийн удирдлага, сэтгүүлч, сурвалжлагчдад 10 жилийн ойн баярын мэнд хүргэж, бурууд хурц, зөвд зөөлөн явахыг ерөөхийн зэрэгцээ үг нь мэргэн, үзэг нь хурц байхыг хүсье.

"Монголын мэдээ" сонин, www.mminfo.mn сайтын хамт олон

Дугаарын **60** мөр

ҮЗЭЛ БОДОЛ

Халаас хоосон
төлөөлөгч түмний төлөө
зүтгэх нь юу л бол
Х.НОРЖИН

АНХЛАН СУРАЛЦАГЧДААР ДҮҮРЭН М.ЭНХБОЛДЫН АНГИЙНХАН



НИМНЦАВБОЛД

2016 оны сонгуулийн дүнд бүрэлдсэн энэ удаагийн парламентын албан ёсны "хичээл" өнөөдөр эхлэх гэж байна. Анхны намрын чуулган нь.

Ээлжит бусаар хэд хонго хуралдсан болж, төсвийн тодотголыг баталсныг эс тооцвол тэд одоо л албан ёсоор хурал хуйгаа хийж, жинхэнэ ажилдаа орох гэж байна. Зөв бодлого гаргаж, эдийн засаг "элгээрээ мөлхсөн" энэ

үед улс орноо орноос салгаж, төсвийн алдагдлаа тэлэхгүй байх үүрэгч тэдэнд л оногдоно. Хэрвээ дээдсүүд зөв бодлого гаргахгүй бол Монгол Улс дампуурлаа зарлахад ганцхан хуруу л үлдээд байна. Ийм хариуцлагатай цаг

үед эхэлж байгаа намрын чуулганы өмнө "Монголын мэдээ" сонин парламентын гишүүдийн өнгийг шинжиж байгаа юм.

Үргэлжлэл нь IV нүүрт

Үргэлжлэл нь III-IV нүүрт




ЛАПША БРЭНД

Монголоос анх удаа Азийн наадмын шагналыг хүртлээ

Азийн Маркетингийн Холбооноос зохион байгуулсан "ASIA MARKETING EXCELLENCE AWARD" шагнал гардуулах ёслол энэ сарын 22-25-ны өдрүүдэд амжилттай болж өндөрлөв. Азийн 16 орны гишүүд, төлөөлөгчид чуулж өнгөрсөн 5-р сард Индонези улсын Бали аралд шалгаруулалтаа явуулсан тус наадамд Монгол улс анх удаа улсаасаа ялагчаа тодруулж, Азийн наадамд Агь компанийн Лапша брэндээрээ оролцсон билээ. Энэхүү наадамд шилдэг, шинэ маркетингтай компани гэсэн номинацид өрсөлдсөн Лапша брэнд маань "ASIA MARKETING EXCELLENCE AWARD" 2016 "Үндэсний ялагч" шагналыг хүртлээ.

Энэхүү наадамд Монгол Улсаас MMX-ны Ерөнхийлөгч Ш.Алтанбагана болон MMX-ны удирдлагын багийн гишүүд, ТЭСО корпораци-"Агь" ХХК-ийн төлөөлүүд ороллоо.

Энэхүү чуулганаар Вьетнам, Тайланд, Индонези, БНСУ, Бангладеш, Филиппин, Япон зэрэг орнуудын маркетингийн шилдэг кэйсүүдийг хэлэлцэж "Asia Marketing Company of the Year" шагналыг "Century Pacific Food Inc" компани авсан бөгөөд Монгол Улсаас "Агь" ХХК - ЛАПША брэндээр "Үндэсний ялагч"-ийн шагналыг гардан авсан юм.

Тус наадмын хувьд жил бүр Азийн орнуудад бүсчилсэн чуулга уулзалтуудыг зохион байгуулж тухайн жил бүрийнхээ ялагчдыг тодруулдаг уламжлалтай наадам юм. Эл наадам жил ирэх бүрт хүрээгээ тэлж байгааг зохион байгуулагчид онцолж байсан бөгөөд энэ удаагийн наадамд оролцогчдыг Гринланд парк болон Самсунг компанийн музей зэргээр аялуулж танилцуулсан нь олон орны төлөөлөгчдийн хувьд мартагдашгүй дурсамж болон үлдсэн юм.

ОНЦЛОХ МЭДЭЭ

УИХ-ын дарга амласнаа биелүүллээ

УИХ-ын дарга, МАН-ын дарга Миеэгомбын Энхболд энэ сарын 02-ны өдөр Төв аймгийн Зуунмод хотноо шинээр баригдсан цэцэрлэгийн нээлтэд оролцлоо. Мөн УИХ-ын даргын урилгаар манай улсад айлчлал хийж буй БНХАУ-ын Коммунист Намын Төв Хорооны Улс Төрийн Товчооны Байнгын хорооны гишүүн Лю Юнь Шань оролцжээ. Цэцэрлэгийг "Хангарьд УВ" ТББ, "Энхтайван" найрамдлын сангийн хамтын ажиллагааны хүрээнд барьж байгуулсан ажээ. Нийт 200-300 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай, хоёр давхар, гаднаа хүүхдийн тоглоомын талбайтай, олон улсын стандартын дагуу баригдсан цэцэрлэгийг УИХ-ын дарга, МАН-ын дарга Миеэгомбын Энхболдын санаачилгаар барьж байгуулсан байна. Гаднах тоглоомын талбай нь хүүхэд тоглоход зориулагдсан зөөлөвч бүхий шалтай, тоглоомууд нь олон улсын стандартын шаардлагыг хангасан, хүүхэд унаж, бэртэхээс сэргийлсэн ажээ. Мөн аймгийн төвд анх удаа олон улсын стандартад нийцсэн цэцэрлэг баригдсан нь УИХ-ын дарга, МАН-ын дарга М.Энхболдын санаачилгаар Төв аймгийн Зуунмод хотод баригдсан дээрх цэцэрлэг болж байна. Энэхүү цэцэрлэгийн байгууламж нь Г.Ганбаяр даргатай "Хангарьд УВ" ТББ, "Энхтайван" найрамдлын сангийн хамтран хэрэгжүүлсэн гурав дахь төсөл болж байгаа юм. Өнгөрөгч оны арваннэгдүгээр сард Чингэлтэй дүүрэгт нээлтээ хийсэн хүүхдийн амбулатори дээрх хоёр байгууллагын хамтран хэрэгжүүлсэн хоёр дахь төсөл нь байв. УИХ-ын дарга, МАН-ын дарга М.Энхболд шинээр бүрэлдсэн парламентын гишүүдээс хамгийн түрүүнд амлалтаа биелүүлж, тойрогтоо цэцэрлэг шинээр барьсан гишүүн болж байна.

ИЛ ЗАХИДАЛ

ГОЛОМТ БАНКНЫ ЭЗЭН Д.БАЯСГАЛАН ТАНАА




Голомт банк нь сүүлийн жил гаруй хугацаанд хууль шүүхийн байгууллагаар хүч түрэн С.В.Паушокскийн үед өөрсдийн хамтран үүсгэсэн хиймэл зээлийн өр төлбөрийг төлүүлэхээр улайран зүтгэлээ.

Хэдийгээр ОУ-ын Арбитрын шүүх, Монгол Улсын шүүхээс хүчин төгөлдөр бус худалдааны болон аккредитивын гэрээний төлбөрийг манай компани хариуцан төлөх үндэслэлгүй болохыг тогтоосон боловч цаашид энэхүү хууль бус үйл ажиллагаанд оролцох, түүний золиос болох шаардлагагүй гэж үзэж байгаа тул "Алтандорнод Монгол" ХХК, "Бумбат" ХХК-ийг 100 хувийн хувьцаа, эд хөрөнгө, тусгай зөвшөөрлүүдийг бүхэлд нь Голомт банкны өмчлөлд шилжүүлэх мэдэгдлийг 2016.09.26-нд танайд хүргүүлсэн.

Үргэлжлэл нь II нүүрт

ХААН банк				Хугалгаа хөгжлийн банк					
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах	
АМ.ДОЛЛАР	2282.00	2295.00	ФУНТ	2911.00	3009.00	АМ.ДОЛЛАР	2284.00	2295.00	
ЕВРО	2524.00	2590.00	РУБЛЬ	34.70	37.60	ЕВРО	2508.00	2620.00	
ИЕН	22.36	22.95	ЮАНЬ	341.00	344.60	ИЕН	22.10	23.24	
							ЮАНЬ	31.91	37.40
								341.00	344.70

МЭДЭЭЛЭЛ

ИЛ ЗАХИДАЛ

ГОЛОМТ БАНКНЫ ЭЗЭН

Д.БАЯСГАЛАН ТАНАА

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Нэг. Голомт банкны нэхэмжлэлтэй С.В.Паушок-ийн ИТОЧУ-той байгуулсан худалдааны гэрээний төлбөрт 2007 онд нээсэн АГ0100080001-АГ0100080005 дугаартай таван аккредитивын гэрээний төлбөрийн 2'092'490'948 иен буюу 34.1 тэрбум төгрөг гаргуулах хэргийг ХУД-ийн иргэний шүүх 2016.09.23-нд хэлэлцэж, уг төлбөрийг гаргуулах илтэд хууль бус шийдвэр гарлаа.

Гэтэл дээрх гэрээнүүд нь Япон Улсын Худалдааны Арбитрын шүүхийн 2013.10.30-ны өдрийн №12-02, №12-03 тоот шийдвэр, Дүүргийн иргэний хэргийн анхан шатны 2-р шүүхийн 2014.11.05-ны өдрийн 3072/Б дугаар шийдвэрээр хүчин төгөлдөр бус худалдааны хэлцэлийн үндсэн дээр хийгдсэн аккредитивын хэлцэл хүчингүй болохыг, мөн уг гэрээний дагуу шилжсэн мөнгийг манайх авч ашиглаагүй бөгөөд үүний төлбөрт ямар ч машин техник орж ирээгүй болохыг шүүхийн шийдвэрт маш тодорхой дүгнэж, "Алтандорнод Монгол" ХХК нь дээрх гэрээнээс үүссэн төлбөр тооцоог хариуцах үндэслэлгүй болохыг эцэслэн тогтоосон.

Гэтэл эцэслэн шийдээд хоёр жил өнгөрсөн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр байхад танай банк хүч түрэн хууль бусаар "Алтандорнод Монгол" ХХК-иар дээрх таван аккредитивийн

мөнгийг төлүүлэх шийдвэрийг гаргуулж, Монгол Улсад шүүх нэг асуудлаар хоёр өөр шийдвэр гаргаж болдог жишгийг тогтоолоо.

Хоёр. Дээрх таван аккредитив нь хуурамч худалдааны 21 гэрээгээр дамжуулан С.В.Паушок-Голомт-ИТОЧУ-МОПС-ийн хийж байсан 7.1 тэрбум иен буюу 159.7 тэрбум төгрөгийн хууль бус санхүүгийн схемийн нэгээхэн хэсэг нь байсан.

Энэхүү схемээр дамжуулан С.В.Паушок-Голомт банк нар нь гадаад улс руу хөрөнгөө Монголын хууль, хяналтын байгууллагаас бултуулан гаргаж, Засгийн газартай шүүхдэлцэх бэлтгэлээ хангаж, хиймэл хохирол бий болгосон бөгөөд тэрбээр алтны 68 хувийн татварын асуудлаар Монгол Улсын Засгийн газрыг ОУ-ын арбитрын шүүхэд өгч нэг тэрбум гаруй ам.долларын хохирол нэхэмжилсэн. Мөн манай хууль, хүчний байгууллага түүнд их хэмжээний татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан.

С. В. Паушок - ИТОЧУ-ГОЛОМТ нар нь тухайн үеийн ханшаар 120 сая ам.долларын машин техник, мөнгөн хөрөнгийг ИТОЧУ-гаас авч Монголруу оруулахгүйгээр ОХУ дахь дундын МОПС компани руу шилжүүлэн авч, харин Монгол дахь "Алтандорнод Монгол" ХХК дээр огт аваагүй бараа, техникийн хиймэл өр үүсгэсэн. Энэхүү ажиллагаанд Голомт банк нь тухайн үедээ өөрийн хөрөнгөөс хэт давсан үнийн дүнгээр /уг нь "Банкны тухай хууль"-иар өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байх заалттай/ ИТОЧУ-гийн харилцагч банкинд барааны төлбөрийг төлөх аккредитивийн мэдэгдлийг хүргүүлж чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд үүнийнхээ хөлсөнд нэлээдгүй их мөнгө авсан билээ.

Мөн энэ аккредитивын төлбөрийн асуудлаар танай банк ИТОЧУ-тай 2013 онд Чингэлтэй дүүргийн шүүхэд шүүхдэлцэж байсан бөгөөд ИТОЧУ болон Голомт банкны хооронд 2013.03.15-нд "Withdrawal agreement" гэрээг байгуулж, нийт 5'203'806'535 иен буюу 88.7 тэрбум төгрөгийн аккредитивийн маргаанаа 1'200'000 ам.доллароор харилцан тохирч хаасан бодит факт, нууц гэрээ тань хүчинтэй байгаа. Энэхүү гэрээ тань Голомт банк анхнаасаа гэрээний дагуу бараа нийлүүлэгддэггүй, худалдааны болон аккредитивын гэрээгээр халхавчилсан санхүүгийн схем гэдгийг мэдэж байсныг нотолдог.

Гурав. Танай банк "Бумбат" ХХК-иас таван эзэлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг шүүхэд нэхэмжилж 28'825'478'053 төгрөгийг гаргуулах, үүргийг барьцааны эд хөрөнгөөр хангахаар шийдвэрлэсэн. Гэвч энэхүү мөнгө нь үндсэндээ компанийн өмнөх удирдлага асан ОХУ-ын иргэн С.В.Паушок-ийн танай банктай хамтарч хийсэн хуурамч гэрээ, түүний ОХУ болон гадаад улс руу хөрөнгөө гаргах зорилгоор эзэмшилд нь байсан "Элладон" ХХК, "Кипрстар" ХХК, "Яхтон" ХХК, "Востокнефтегаз" ХХК зэрэг компаниудад үүсгэсэн хугацаа хэтэрсэн хиймэл эзэлийн

өрийг эзэлээр хааж, шинэ эзэл болгоход зориулагдсан билээ.

Дөрөв. С.В.Паушок-ийн эзэмшилд байсан "Востокнефтегаз" ХХК-ийн бүх хөрөнгийг одоогоос гурван жилийн өмнө 2013 онд Засгийн газар, Төрийн өмчийн хорооны тогтоол, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар татварын өрөнд хурааж, төрийн өмчид шилжүүлсэн. Тус компанийн хөрөнгийг шилжүүлэхэд танай банкны гүйцэтгэх захирал, эрсдийн удирдлагын захирлууд тухайн үедээ бичгээр барьцааны хөрөнгийг татварт өгөхийг зөвшөөрч, оронд нь компанид орж ирсэн орлогоор банкны эзэлээ мөнгөөр төлүүлж байсан билээ.

Гэтэл гурван жилийн

дараа шүүхийн шийдвэрээр дампуураад татан буугдсан компани дээр 22.1 тэрбум төгрөгийн төлбөр гаргуулах, түүнийг нь төрийн өмчид өөрөө зөвшөөрөл өгч шилжүүлсэн одоо ХХААЯ-ны ТЭЛС-гийн эзэмшилд байгаа 25.3 тэрбум төгрөгийн үнэтэй Нефть хангамжийн баазаар төлүүлэх шүүхийн шийдвэрийг 2016.05.19-нд хүчээр гаргуулжээ.

Нүд улаан, мөнгө цагаан боловч та бүхэн дампуураад татан буугдсан хувийн компанийн өрийг төрийн өмчийг дээрэмдэн авч төлүүлж байгаа энэхүү үйлдлээсэ нчих хэрэгтэй! Аргагүй олон жил худлаа тайлан мэдээ гаргаж төр олон нийтийг хуурч ирсэн үйлдлүүд чинь өөр зам үлдээгээгүй байх.

Хэдийгээр энэ компаниудын хувьцааг худалдан авсан эзэлийн төлбөрт танай банкинд нийт 33.1 тэрбум төгрөг буюу тухайн үеийн ханшаар 25 сая ам.доллар төлсөн боловч бидний зүгээс цаашид ийм хууль бус үйл ажиллагаанд орооцолдож, түүний золиос болох, хөрөнгө болж орж ирээгүй, хэсэг хүмүүсийн хууль бус ажиллагаагаар үүссэн хиймэл өр, төлбөрийг өмнөөс нь төлж барагдуулах ямар ч боломжгүй бөгөөд ийм шаардлага ч байхгүй тул хөрөнгөөсөө татгалзаж, танай банкинд шилжүүлж байна.

Иймд Монгол Улсын банк санхүүгийн салбар, эдийн засгийг хордуулахад 20 гаруй жилийн туршид голлон оролцсон Голомт банкны

эрхэм удирдлага Д.Баясгалан та, "Алтандорнод Монгол" ХХК, "Бумбат" ХХК-иас 100 хувийн хувьцаа, эд хөрөнгө, тусгай зөвшөөрлүүдийг шилжүүлэн авч тус банкны гүйцэтгэх захирлын албан тушаалд ажиллаж байхдаа өөрөө гарын үсэг зурж, С.В.Паушоктой байгуулсан аккредитивын болон эзэлийн гэрээний хиймэл өр төлбөрөө өөрөө барагдуулна уу!

Жич: Голомт банкны хууль бус үйл ажиллагааны дараагийн цуврал мэдээллийг www.adm.mn-ээс /сайт хаагдсан тохиолдолд гадаадын хэвлэл мэдээллийн сувагаас/ үзнэ уу!

"АЛТАНДОРНОД МОНГОЛ" ХХК, "БУМБАТ" ХХК

ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ 2 ДУГААР ШҮҮХИЙН ТОГТООЛ

2014 оны 02 сарын 07 өдөр Дугаар 589 Улаанбаатар хот

Withdrawal Agreement

ITochu Corporation
Golomt Bank of Mongolia

Date: March 15, 2013

Parties: ITochu Corporation of 5-1, Kita-Aoyama 2-chome, Minato-ku, Tokyo 107-8077, Japan ("ITochu")

And
Golomt Bank of Mongolia of Sukhbaatar Square, Ulaanbaatar 210620A, Mongolia ("Golomt Bank").

Батлав, Голомт Банкны Гүйцэтгэх Захирал Д.Баясгалан

АККРЕДИТИВЫН ГЭРЭЭ
2007 оны 07 сарын 05-ны өдөр Дугаар АГ0100080001 Улаанбаатар хот

Батлав, Голомт Банкны Гүйцэтгэх Захирал Д.Баясгалан

АККРЕДИТИВЫН ГЭРЭЭ
2007 оны 07 сарын 05-ны өдөр Дугаар АГ010008000А Улаанбаатар хот

Батлав, Голомт Банкны Гүйцэтгэх Захирал Д.Баясгалан

АККРЕДИТИВЫН ГЭРЭЭ
2007 оны 07 сарын 05-ны өдөр Дугаар АГ0100080004 Улаанбаатар хот

Батлав, Голомт Банкны Гүйцэтгэх Захирал Д.Баясгалан

АККРЕДИТИВЫН ГЭРЭЭ
2007 оны 07 сарын 05-ны өдөр Дугаар АГ0100080005 Улаанбаатар хот

THE JAPAN COMMERCIAL ARBITRATION ASSOCIATION
Arbitration Case No. 12-02 and No. 12-03, Tokyo

ITochu CORPORATION (JAPAN)
CLAIMANT
v.
GOLDEN EAST MONGOLIA LLC (Mongolia)
RESPONDENT 1
VOSTOKNEFTEGAZ LLC (Mongolia)
RESPONDENT 2

ARBITRAL AWARD

ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ

2009 оны 07 сарын 06 өдөр Дугаар 1021 Улаанбаатар хот

ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ 2 ДУГААР ШҮҮХИЙН ШИЙДВЭР

2014 оны 11 сарын 05 өдөр Дугаар 3072/Б Улаанбаатар хот

БУМБАТ ХХК
Махатаа Гандийн гудамж-39, Корпорат
Хотел энд Конвеншн центр, 8-р давхар
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар - 17011
Монгол улс
Утас: (976) 7700 227, Факс: (976) 7700 3377
info@adm.mn
www.adm.mn

2016.09.26 № 16/94
Танай "Бумбат" ХХК-ийг шилжүүлэн авах тухай мэдээлэл

ГОЛОМТ БАНКИНД

Танай банкны нэхэмжлэлтэй ЗГ8115005289, ЗГ8115005290, ЗГ8115005883, ЗГ8115005228, ЗГ8115005384 дугаартай эзэлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг нэхэмжилсэн иргэний хэргийг УДШ-ийн 2016.07.01-ний өдрийн хурлаар хэлэлцэж, 28'825'478'053 төгрөгийг гаргуулах, үүргийн гүйцэтгэлийг бараацааны эд хөрөнгөөр хангахаар шийдвэрлэсэн.

Дээрхи нэхэмжилсэн мөнгө нь үндсэндээ компанийн өмнөх удирдлага асан ОХУ-ын иргэн С.В.Паушок-ийн танай банктай хамтарч хийсэн хуурамч худалдааны болон аккредитивийн гэрээнүүд, түүний ОХУ болон гадаад улс руу хөрөнгөө гаргах зорилгоор эзэмшилд нь байсан "Элладон" ХХК, "Кипрстар" ХХК, "Яхтон" ХХК зэрэг компаниудад үүсгэсэн хиймэл эзэлийн өрүүдийг хөрвүүлж, эзэлийг эзэлээр хаахад зориулагдсангай та бүхэн ийм мэдэж байгаа билээ.

Та бүхэн нэгэнт энэ компанид бодит хөрөнгө болж орж ирээгүй эзэлийн өрөө бүхэлд нь төлүүлж, түүнийгээ барьцаа хөрөнгөөр хангуулах хүсэлтийг чинь шүүх хангасан, мөн бид бүхний зүгээс цаашид тус компанийн авч явахтай холбогдох татвар хураамж, тусгай

АЛТАН ДОРНОД МОНГОЛ ХХК
Махатаа Гандийн гудамж-39, Корпорат
Хотел энд Конвеншн центр, 8-р давхар
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар - 17011
Монгол улс
Утас: (976) 7700 227, Факс: (976) 7700 3377
info@adm.mn
www.adm.mn

2016.09.26 № 16/192
Танай "Алтандорнод Монгол" ХХК-ийг шилжүүлэн авах тухай мэдээлэл

ГОЛОМТ БАНКИНД

Танай банкны нэхэмжлэлтэй ИТОЧУ-гийн худалдааны гэрээний төлбөрт нэсэн таван аккредитивын гэрээний төлбөрийн 2'092'490'948 иен буюу 34'107'602'452 төгрөгийн нэхэмжлэлийг ХУД-ийн Иргэний хэргийн шүүх 2016.09.23-нд хэлэлцэж, "Алтандорнод Монгол" ХХК-иас уг төлбөрийг гаргуулах илтэд хууль бус шийдвэр гарлаа.

Дээрхи гэрээнүүд нь Япон улсын Худалдааны Арбитрын шүүхийн 2013.10.30-ны өдрийн №12-02, №12-03 тоот шийдвэр, Дүүргийн иргэний хэргийн анхан шатны 2-р шүүхийн 2014.11.05-ны өдрийн 3072/Б дугаар шийдвэрээр Иргэний хуулийн 56.1.10-т зааснаар хүчин төгөлдөр бус худалдааны хэлцэлийн үндсэн дээр хийгдсэн аккредитивын хэлцэл хүчингүй болохыг, мөн уг гэрээний дагуу шилжсэн мөнгийг ИТОЧУ авсан тул бусдын мөнгийг үндэслэлгүйгээр олж авсан болохыг, манай компанид энэ гэрээний дагуу ямар ч машин техник нийлүүлэгддэггүй болохыг шүүхийн шийдвэрт маш тодорхой дүгнэж "Алтандорнод Монгол" ХХК нь аккредитиваас үүссэн төлбөр тооцоог хариуцахгүй болохыг эцэслэн тогтоосон.

Гэтэл эцэслэн шийдээд 2 жил өнгөрсөн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр байхад танай банк хүч түрэн хууль бусаар "Алтандорнод Монгол" ХХК-иар дээрх таван аккредитивийн мөнгийг төлүүлэх шийдвэрийг сая гаргууллаа.

Энэ мөнгө нь өмнөх удирдлага асан С.В.Паушок-ийн танай банктай хамтарч хийсэн хуурамч худалдааны болон аккредитивийн гэрээгээр гадаад улс руу хөрөнгөө хууль, хяналтын байгууллагаас бултуулан гаргахад үүссэн хиймэл өр болохыг та бүхэн сайн мэдэж байгаа билээ.

Мөн танай банк ИТОЧУ-тай дээрхи аккредитивийн асуудлаар шүүхдэлцэж, улмаар ИТОЧУ ба Голомт банкны хооронд 2013.03.15-нд "Withdrawal agreement" гэрээг байгуулж, нийт 5'203'806'535 иен буюу 88'784'274'557 төгрөгийн аккредитивийн маргаанаа 1'200'000 ам.доллароор харилцан тохирч хаасан бодит факт, нууц гэрээ тань хүчинтэй байгаа билээ.

Бидний зүгээс цаашид ийм хууль бус үйл ажиллагаанд орооцолдох, авч хэрэгцээгүй хиймэл өр, төлбөрийг төлж барагдуулах ямар ч боломжгүй ба ийм шаардлага ч байхгүй.

Иймд танай банк хиймэл өрөө хууль бус шүүхийн шийдвэрээр хүч түрэн авахаар зүтгэж байгаа тул барьцаанд байгаа тусгай зөвшөөрөл, эд хөрөнгө болон "Алтандорнод Монгол" ХХК-ийн 100%-ийн хувьцааг хүлээн авах ажлын хэсгээ томилж 2016.09.30-ны дотор хүлээн авна уу.

Жич: Бид 9-р сарын 30-наас хойш www.adm.mn-ээс /сайт хаагдсан тохиолдолд гадаадын хэвлэл мэдээллийн сувагаас/ үзнэ уу!

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.БАЯСГАЛАН
АЛТАН ДОРНОД МОНГОЛ ХХК
М.ИДЭР

MMINFO

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч: Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчлаганы алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

MMINFO

Тал нутгийн цахим мэдээлэл

Е-mail: mongolin_medee@yahoo.com Утас: 976-11-70113551 Факс: 976-70113551 Реклам, зар сурталчлаганы алба: 99173710

ҮЗЭЛ БОДОЛ

АНХЛАН СУРАЛЦАГЧДААР ДҮҮРЭН М.ЭНХБОЛДЫН АНГИЙНХАН

1-р бүлэг буюу МЭРГЭШСЭН ПАРЛАМЕНТЧИД



2-р бүлэг буюу ХҮҮЧҮҮЛ ДУНДАХ ШИНҮҮД



3-р бүлэг буюу БЭЛТГЭГДСЭН ҮЛСТӨРЧИД



Энэ удаагийн парламентын 76 гишүүн дунд мэргэшсэн гэж дүгнэж болохоор 23 хүн л байна. Юуны өмнө УИХ-д сонгогдсон тоогоор нь ингэж дүгнэж байгаа юм. Парламентад хоёроос дээш удаа сонгогдож, найм дахь удаагаа сууж байгаа хүн гэдэг жинхэнэ утгаараа мэргэшиж таараа биз дээ. Тухайлбал, УИХ-ын Ц.Нямдорж, Д.Лүндэжжанцан нар 1992 оноос хойш тасралтгүй сууж байгаа. Хоёулаа УИХ-ын дарга байсан. Ц.Нямдорж гишүүний хувьд Хууль зүйн сайдаар ажиллаж байсан хүн. Тэр утгаараа хамгийн архаг, мэргэшсэн хуульчид. Ер нь энэ хоёр гишүүн шиг хуулийн чиглэлээр мэргэшсэн, гүнзгийрсэн түшээ УИХ-д бараг байхгүй гэж магтъя. Харин УИХ-ын дарга М.Энхболд, гишүүн Ө.Энхтүвшин, Н.Энхболд, Ч.Улаан, Д.Тэрбишдагва, Д.Оюунхорол, Л.Болд, Б.Бат-Эрдэнэ, С.Батболд гээд ихэнх нь УИХ-д 4-5 удаа сонгогдсон гишүүд байна. Улс орныг удирдан залах, жолоог нь яаж атгах, хууль хэрхэн санаачлах, боловсруулах, салбар яамыг хэрхэн удирдах гээд бүхий л зүйлд мэргэшиж байгаа нөхдүүд. Гэх мэтээр дурьдаад байвал Д.Эрдэнэбат, С.Бямбацогт гээд чадалтай, чадвартай гишүүд энэ удаагийн УИХ-д олон л байна. Бүх гишүүдийн бараг 30 хувь нь мэргэшсэн парламентчдын тоонд багтана.

Харин Сангийн сайд Б.Чойжилсүрэн гэх мэт зарим нэг хүнийг хоёроос дээш жил УИХ-д сууж байгаа гэдэг утгаар нь энэ бүлэгт багтааж байгаа юм. Яг үнэндээ мань хүн энэ хугацаанд мэргэшиж чадсан уу гэдэг нь ч бас эргэлзээтэй. Өнгөрсөн найман жилийн хугацаанд дуугүй суусан, суралцъя гэж бодож байгаагүй ч байж болох. Харин одоо бол Засгийн газрын хамгийн чухал салбарын сайд болсон учир хууль санаачлах, боловсруулах энэ тэр асуудалд нэлээд нухацтай, анхааралтай хандаж, ярьж хөөрч эхэлж байх шиг байна. Мэргэшсэн нөхдүүд дотор ганц хоёр иймэрхүү үлстөрчид байгаагийн жишээ энэ. Хамгийн гол нь энэ хүмүүс одоогийн парламентад түүчээ болж, хүнд хэцүү үед улс орныг зөв удирдаж, хүндрэлээс гарах бүхий л арга замыг олох ёстой. Тэгээд ч энэ бүлэгт багтаж байгаа гишүүдийн цөөнгүй хэд нь салбарын сайд хийж байгаа. Мөн УИХ-ын дарга ч давхиж яваа юм. Тиймээс гол ачааг үүрч, зөв бодлогыг гаргахад та хэд зөв оройлоосой гэж хүсье. Энэ удаагийн сонгуульд МАН үнэмлэхүй олонхи болсон. Тэд 65 суудалтай. Тиймээс МАН-ын мэргэшсэн парламентчид одоо л жаахан сэтгэл гаргаад, улсаа шигдэж байгаа “шавар”-наас нь гаргах хэрэгтэй дээ. Хувийн жижигхэн амбийцаа хаявал зүгээрсэн.

Энэ удаагийн парламентад хоёр дахь удаагаа сонгогдож байгаа гишүүд 10 гаруй бий. Тэд бол парламентад найман удаа суусан, гурваас дээш удаа сонгогдож байгаа нөхдүүдийн дунд бол арай л шинэдээ орно. Ерөнхийдөө өнгөрсөн дөрвөн жил УИХ-д сууж, “мэргэжил” эзэмшээд, дээшлүүлээд гарсан гэсэн үг. Монгол төдийгүй дэлхий дахинд мэргэжил олгох дээд боловсролыг дөрвөн жилийн хугацаанд олгодог биз дээ. Ингэж бодож үзвэл энэ бүлэгт хамаарч байгаа гишүүд одоо л мэргэжилтэн болж, төрд ажиллаж чадахаар болж байна аа л гэсэн үг. Дөрвөн жилд сурсан, мэдсэн, олж авсан бүхнээ одоо ашиглах цаг. Нэг үгээр хэлбэл, парламентын шинэ ажиллах хүчин. Ямар ч байгууллагад шинэ төгссөн оюутан ирээд, хэд хоногийн хугацаанд учраа олоод, дараа нь шижигнэсэн боловсон хүчин гэгддэг биз дээ. Түүнтэй адилхан л гэсэн үг. Тухайлбал, Ж.Эрдэнэбат гишүүн гэхэд хоёр дахь удаагаа сонгогдож, одоо Ерөнхий сайдын албан тушаалд суулаа. Улс эх орны төлөө зүтгэх шижигнэсэн боловсон хүчин. Харин өнгөрсөн хугацаанд сурсан мэдсэн бүхнээ улс орныхоо сайн сайхны төлөө зөв бодлого гаргаж, ашиглаж чадах уу л гэдэгт байна. Уг нь Ж.Эрдэнэбатын Засгийн газар замбараагүй төсвөө хэмнэлтийн горимд шилжүүлж, төрд байгаа нөхдүүдийн тансаглалыг танах шийдвэр гаргасан. Тэгсэн хэр нь хүүхэд эмэгтэйчүүд, хөгшчүүд хатуурхаж байгаад хэн хүнгүй гонсойсон. Зөв шийдвэр, зоримог ажлыг шижигнэсэн боловсон хүчнүүд л хэрэгжүүлдэг. Харамсалтай нь архагууддаа даруулчих шиг боллоо.

Үргэлжлэл нь IV нүүрт

Энэ удаагийн сонгуулиар маш олон хүн анх удаа УИХ-ын гишүүн болсон. Гэхдээ тэр дунд өмнө нь төрийн албанд хангалттай олон жил ажилласан, яам тамгын газарт алба хашиж байсан хүн цөөнгүй бий. Ерөнхийдөө бэлтгэгдчихсэн үлстөрчид гэсэн үг л дээ. МАН-ын генсек Ж.Мөнхбатыг арай ч анхлан суралцагч гэхэд хэцүү. Нэг том намын Ерөнхий нарийн бичгийн дарга байсан, улс төрд цөөнгүй хэдэн жил “чанагдсан” учраас энэ бүлэгт багтаж болохоор. С.Чинзориг гишүүний хувьд энэ дундаасаа хамгийн туршлагатай, мэдлэг чадвартай, боловсорсон үлстөрч, мэргэшсэн төрийн албан хаагч. Хэдийгээр УИХ-д анх удаа сонгогдож байгаа хэдий ч зарим нэг 3-4 сонгогдож, парламентад сууж байгаа хүнээс ч илүү гэж хэлж болохоор. Тэр дундаа хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр мэргэшсэн. Энэ салбарын бүхий л хууль тогтоомж түүнтэй салшгүй холбоотой. Өнгөрсөн дөрвөн жилд тур зуур ч гэсэн Хөдөлмөрийн сайд хийхдээ салбартаа хэрэгтэй чухал хуулиудыг гаргаж чадсан. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайдаар найман жил ажиллахдаа энэ салбарын гол хуулиудыг боловсруулалцаж, батлуулсан гэж болно. Б.Саранчимэг гишүүн НИТХ-ын төлөөлөгч байсан. УИХ-ын Тамгын газар гээд төрийн албанд цөөнгүй жил ажилласан. Ерөнхийдөө бодлого боловсруулах, хууль санаачлах энэ тэр гээд бүхий л асуудлыг сайн мэднэ. Ийм л туршлагатай үлстөрч. Гэх мэтээр сайтар бэлтгэгдсэн, дэд сайд, сайд байсан үлстөрчид цөөн хэд байна. Энэ хүмүүс нрэх дөрвөн жилд парламентын гол цөмийн нэг байж, улс оронд хэрэгтэй хууль тогтоомж, зөв бодлогыг гаргаж ажиллах болов уу. Тийм ч хэрэгцээ шаардлага байна.

УЛС ТӨР

АНХЛАН СУРАЛЦАГЧДААР ДҮҮРЭН М.ЭНХБОЛДЫН АНГИЙНХАН

2-р бүлэг буюу ХУУЧУУЛ ДУНДАХ ШИНҮҮД

Үргэлжлэл.
Түрүүч нь III нүүрт

Мөн өнгөрсөн дөрвөн жилд элдэв асуудалд хутгалдахаас өөр ажил бараг хийгээгүй Н.Номтойбаяр гишүүн энэ удаад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болж, салбарын “боловсрол”-ыг эзэмшихээр суралцаж байна. Гэхдээ дөрвөн жил УИХ-д сууж, боловсорсон хүн арай л өөр ажиллах байх гэж найдаж сууна. Мөн Д.Сумъяабазар, О.Содбилэг, Л.Энх-Амгалан, Я.Содбаатар, Д.Сарангэрэл гэх мэт МАН-ын гишүүдийг өнгөрсөн хугацаанд сурсан мэдсэн, олж авсан мэдлэгээ архагуудын санаа бодолтой нийлүүлж, Монгол Улсаа өөд нь татахад хамгийн гол оролцогч нь байгаасай гэж хүсч байна. Одоо энэ хүмүүст суралцаж суух биш улсаа өөд нь таталцаж ажиллах л хугацаа ирчихлээ. Я.Содбаатар гишүүн бол хоёр дахь удаагаа сонгогдсон. Өмнө нь дэд сайдаар хүртэл ажиллаж явсан хүн. Харин Д.Сарангэрэл гишүүн сэтгүүлчийн хувьд салбарынхаа төлөө дуугарч байсан, одоо энэ дөрвөн жилд дрвитой шидивэр гаргуулж чадах буй за. За тэр О.Баасанхүү, Б.Наранхүү, Ж.Батзандан гэх мэт сөрөг хүчний гишүүд яах вэ. Ганц нэг хууль санаачлаад, батлуулж чадвал их юм. Ихэнхдээ ярих л боломж олдох байх. Өөрөөр ч яах билээ.

Дугаарын 60 мөр

Халаас хоосон төлөөлөгч түмний төлөө зүтгэх нь юу л бол

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Ардчилсан намын тухайд өмнө нь НИТХ-д нэр дэвшиж байсан туршлагатай хуучуул нь явган самбаруудаа байшингийн булан, явган хүний зам, орц бараадуулан байршуулснаас хэтрээгүй. Шинэ нэр дэвшигчид нь ая эвээ олохгүй яваа юу, мөнгөгүйдэд баларч яваа ч байж мэднэ. Орон нутагт мөнгө байхгүй гээд намынхаа даргаар бүх зардлаа гаргуулчих санаатай нэр дэвшигчид цөөнгүй байна гэж дуулдсан. Энгийн иргэдийн хувьд УИХ болоод аймаг, нийслэлийн ИТХ-д нэр дэвшинэ гэдэг ямар ч тохиолдолд төр, иргэн хоёрынхоо өмнө хариуцлага хүлээх чадвар бүхий эрдэм боловсролтой чухамхүү биеэ засчихаад төрөө засахын төлөө зүтгэхэд бэлэн хүнийг л илгээдэг хэмээн боддог. Гэвч орон нутгийн сонгуульд нэр дэвшиж буй хүмүүсийн дийлэнх нь ялангуяа, хүн ам цөөтэй сумдын хувьд шулуухан хэлэхэд, дурнаас цаашгүй шалдан гуяауд байгаа бололтой. Үнэндээ тэдэнд улс төрийн үзэл баримтлал гэж байдаг ч үгүй гэнэ билээ. Суманд нөлөө бүхий этгээдүүд хаашаа ханарна, тэднийг дагаад л салхи шиг дэрвэж явдаг нөхдүүд гэсэн. Халаас нь ч хоосон. Яах вэ, хүнд үзүүлэх юмгүй малчин, тариачныг бодвол эрх биш дээд сургууль төгссөн гээд зогсч байх дипломтой л юм биз. Ийм л нөхдүүд эгэл ардыг төлөөлж орон нутгийг удирдах дээд шатны байгууллага болох ИТХ-д төлөөлөгчөөр сонгогдох мөрөөдөлдөө умбацгаажээ. Хүн амаасаа хамаарч нэг нэр дэвшигч доод зах нь 1000 өрхийг төлөөлөх биз. Нэр дэвшиж байгаа хүн тойргийнхоо сонгогчдод миний, манай намын мөрийн хөтөлбөр энэ гээд үзүүлээд, тараагаад явах нугалбар ч болтугай материалтай байх ёстой бус уу. Гэтэл намынхаа мөрийн хөтөлбөрийг байг

гэхэд өөрийнхөө хэн болохыг илтгэх бичгийн цаасны хэмжээтэй цаасан дээр өнгөтэйгөөр хэвлүүлээд тараах материалаа хэвлүүлэх мөнгө олдохгүй юм гээд гуйрамч царайлаад явж байгаа нэр дэвшигчтэй өчнөөн тааралдлаа. Гудамжинд тааралдаад нэр дэвшиж буйгаа сайрхан ярих атлаа хандив гуйх нь инээдмтэй. УИХ-д нэр дэвшээд хэдэн сумын нутаг дэвсгэрийг хамарсан том тойрогтой бол хөөрхий гэхсэн. Үнэндээ мянган ширхэг А4 хэмжээтэй дөрвөн нүүр бүхий тараах материалыг хэвлэх үнэ ширхэг нь 200 төгрөг гэхээр мянга нь 200 мянган төгрөг болж байгаа юм. Дээр нь эх бэлтгэлийн 100 мянган төгрөг нэмэгдэх биз. Энэ зардлаас гадна сурталчилгаандаа ажиллуулах хоёр гурван хүнээ юугаараа цалинжуулах юм бол. Яах вэ, ах дүү, төрөл садан, найз нөхдөө үнэгүйгээр дайчилж болно л доо. Тэгээд ч улс төрийн намууд тухайн тойрогт нэр дэвшигчдээ багаар нь илгээж буй. Тэгэхээр хэвлэлтийн болоод эх бэлтгэлийн нийт зардлаа хоёр, гурван хүндээ хуваахаар хямдавтар ботинкны үнэтэй дүйж очиж байгаа юм. Инээдтэй байгаа биз дээ. Эсвэл манай улстөрчид ийм инээдэмтэй болчихсон юм уу. Сардаа 400 мянган төгрөг төлөөд байр хөлсөлж суугаа залуучуудаас л дор байв гэж дээ, амьдрал нь. Түрээслэгчид сар бүхний тодорхой нэг өдөр түрээсээ төлөх гэрээтэй. Нэр дэвшигч дөрвөн жилд нэг удаа халаасаа тэмтрээд ч 200-300 мянган төгрөг гаргаж чадахгүй байгаа юм бол ИТХ-д сууна гэж дэвшээд ч яах юм билээ дээ. Тэдэнд хандаж хэлэхэд, эхлээд өөрийгөө болон амьдарч буй гэрээ засчихаад, халаасандаа хэвлэлтийн зардалтай болчихоод төрөө засах тухай бод гэмээр байна. Гэр ч үгүй, мөнгө ч үгүй нэр дэвшигчийн юунд нь болж итгэлээ өгөх билээ дээ.

4-р бүлэг буюу “БОР ХАЛЗАН ХОНИНУУД”



2016 оны сонгуулиар МАН-аас өрсөлдсөн “бор халзан төлөг”-ийг ч ард түмний 40 гаруй хувь нь сонгосон. Тэгвэл энэ удаагийн парламентад юугаа ч мэдэхгүй, “цэл ногоон”, нөгөө ард түмний яриад, хэвлэлийнхний тодорхойлоод байгаа “бор халзанууд” бараг л 45 орчим хувийг нь эзэлж байна. Яах вэ, өмнө нь төрийн албанд ганц нэг алба хашиж байсан нөхдүүд бий л дээ. Гэхдээ л ихэнх нь хувийн бизнесээ хийгээд явж байсан хүмүүс. Ийм л гишүүд парламентын бараг тал хувийг шахам бүрдүүлж байгаа нь нэг талаараа тун харамсалтай байгаа юм. Улс орон өнөөдөр ямар хэмжээнд хүрчихээд байгаа билээ. Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өссөн хэдхэн жилд манай эдийн засаг дэлхийд тэргүүлэхээр өсөлттэй гарч байсан. Тэгвэл өнөөдөр уул уурхайн бүтээгдэхүүний үнэ дэлхийд унаж, Хятадын эдийн засаг жаахан бууралттай болохоор “элгээрээ хэвтчихээд” байна. Яг одоогоор нөхцөл байдал маш хүнд байгаа. Зөв л бодлого баримталж, эдийн засгаа хурдан хугацаанд аварч авахгүй бол дампуурах орны тоонд багтчихаад байгаа. Ирэх он гаргаад бид зээлээ толж эхэлнэ. Гэтэл төсвийн алдагдал нь хэчнээн төгрөгт хүрээд байгаа билээ. Ийм эгзэгтэй үед Засгийн газар төсвөө ч хэмнэж чадахгүй байна. Гэтэл УИХ-ын гишүүдийн бараг

тал нь энэ мэтийг ойлгохгүй шахам, бусдын яриаг сонсоод, намынхаа нөхдүүдийг дагаж товчлуур дарсан байдалтай байхаар яана аа. Хэн дарга нарынхаа зөв, бурууг шүүж, хэлж, сануулж байх вэ. Энэ ч эмгэнэлтэй хэрэг шүү. Нэг жишээ хэлье, саяхны. Төрийн албан хаагч нар тэтгэвэрт гарахдаа 36 сарын цалинтай дүйцэхүйц тэтгэмж авна гэсэн заалтыг энэ мэтийн кнопочингуудын хар гайгаар цуцалчихаад байгаа шүү дээ. Одоо “бор халзан хонинууд” тойрогтоо очиж, сонгогчидтойгоо уулзмар аядахдаа юу гэж хэлж хуйхаа маажих гэж байгаа бол доо, зайлуул. Мэдээж энэ бүлэгт багтсан 30 гаруй хүн дөрвөн жил суралцана. Өмнөх парламентад оймсонд хавчуулагдаж орж ирээд, сайд, байнгын хорооны дарга болж байсан нэг хүүхэн “Би өнгөрсөн дөрвөн жилд маш их зүйлийг сурч авлаа. Бараг нэг дээд сургууль төгссөнтэй адил” гэх маягийн юм яриад байсан даа. Тэд дөрвөн жилийн дараа ийм л юм яриад сууж байх нөхдүүд шүү дээ. За тэгээд “бор халзанууд”-д энэ дөрвөн жилд хичээлээ сайн судалж, хурлаа битгий таслаарай л гэж хүсье дээ. Уг нь аль болох хурдан суралцаад, ядаж хоёр жилийн дараа хуулийн төслийн аль нь иргэдэд хэрэгтэй вэ гэдгийг ялгаж салгаад, дарга нартаа ганц нэг юм хэлчихдэг болбол сайнсан.

УЛС ТӨР



АМЛАЛТААСАА БУЦАГСДАД АХИАД ХУУРТАХГҮЙ
Монголын ард түмэн

Д.ЭРДЭНЭБАТ: ХУДЛАА АМЛАЛТАД НЬ ИТГЭЛ АЛДАРЧ, СЭТГЭЛ ЦӨХӨРСӨН АРД ОЛОН “АМЛАЛТАА МАРТАГСДАД АХИАД ХУУРТАХГҮЙ” ГЭЖ ХАРИУЛЖ БАЙНА

Ардчилсан намаас аймаг дүүрэг, сумын Иргэдийн Хурлын төлөөлөгчдийг сонгуульд нэр дэвшигчид энэ сарын 1-ний өдрөөс албан ёсоор сурталчилгаагаа эхлүүлээд байна. Орон нутгийн сонгууль эхэлж буйтай холбогдуулан Ардчилсан намын сонгуулийн ерөнхий менежер Д.Эрдэнэбат болон АН-ын гишүүдийн төлөөллийн үгийг хүргэж байна.

“Эх оронд маань сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгууль эхлэх гэж байна. Энэ бол өнгөрсөн зун, зургадугаар сарын 29-нд болсон УИХ-ын сонгуулиас хойш 100 хоногийн дараа сонгогчдын саналаа илэрхийлэх төрийн хоёр дахь сонгууль юм.

УИХ-ын сонгуулиас хойш 100 хоногт юу болоод өнгөрөв гэдгийг эргэж нэг дүгнэн сонголтдоо баталгаажуулах гэхээсээ илүү сонголтдоо дун тавих өдөр юм.

Улсын хэмжээнд нийт сонгогчдын 45 хувийн санал авсан ч УИХ-ын суудлын 86 хувийг дангаараа бүрдүүлэх боломжийг мажоритар сонгуулийн тогтолцоо Ардын намд олгосон. Гэхдээ Ардчилсан намд ч мөн нийт сонгогчдын 33 хувь саналаа өгсөн юм. УИХ-ын сонгуульд манай нам, манай намаас нэр дэвшигчдийг дэмжиж саналаа өгсөн нийт сонгогчиддоо

намынхаа нөхдийн өмнөөс чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Өнгөрсөн зун болж өнгөрсөн УИХ-ын сонгууль хэдийгээр зөрчил, гомдол олон байсан ч үр дүн нь Монголын ард түмэн Монгол Ардын Намд итгэл хүлээлгэсэн.

Энэхүү сонголтыг манай нам улс төрийн соёлтойгоор хүлээн зөвшөөрч “Амлалтаа биелүүлж, ажлаа хий” гэсэн ард түмний итгэлийг битгий хөсөрдүүлээрэй гэж МАН-д төрийн эрхийг шилжүүлэн өгч байсныг Монголын ард түмэн одоо ч мартаагүй байгаа.

Харин МАН-ын Мэргэжлийн Засгийн газар амласнаа биелүүлж ажлаа эхлүүлэх 100 хоногийн хэрхэн үзэв?

Албан татвараар далайлгаж, албан тушаалдаа хөөрцөгдөсөн өдрүүд байв уу гэдэгт олон түмэн өөрсдийн дүгнэлтээ өгөх нь лав.

Эрх баригчид ноёрхож, улс орны эдийн засаг, жирийн иргэд, төрийн албан хаагчдын ажил, амьдралд сөргөөр нөлөөлөх шийдвэрүүдийг хүч түрэн гаргасаар байна.

2012-2016 онд Ардчилсан намын Засгийн газраас шаг шатандаа хийсэн, их бүтээн байгуулалтуудыг санаатайгаар үгүйсгэх, түүний үр дүнг харлуулах сөрөг сурталчилгааг улайран хийж байгаа өнөөдрийн эрх баригчид нэгэнт эхлүүлээд, эхлүүлсэн нь цаасан дээр бус

бодит ажил болон дуусч буй ажлуудад ёслолын тууз хайчлан зогсох нь сүүлийн үед элбэгшиж байна

Айл бүрт тараасан гоё амлалтаар ард түмний итгэлийг авсан мөрийн хөтөлбөрийн биелэлт эхний 100 хоногт хэрхэн биелсэн захын жишээг дурьдая.

МАН мөрийн хөтөлбөртөө “Төрийн байгууллагыг удирдаж байгаа хүмүүс ах дүү, хамаатан саднаа ажилд давахыг хориглоно” гэсэн ч хэн даргын хүү, дүү, бүр эхнэр нөхөр ямар ажил албанд томлогдсоныг бүгд мэдэж байгаа.

“Мэргэжлийн Засгийн газар байгуулна, УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүнээр давхар ажиллахыг хязгаарлана” гэсэн ч хэдэн сайд нь “давхар дээлтэй”, хэчнээн сайд нь мэргэжлийнх, эс мэргэжлийнх болохыг ард түмэн харж байгаа.

“Хүүхэд бүрт хүүхдийн мөнгө олгоно” гэсэн ч ард олны хүүхдийг алаг үзэн, ялгаварчилж олгохоор боллоо.

“Цалинж жил бүр үе шаттай нэмэгдүүлнэ” гэж амласан ч нэмэх биш хасах тухай шийдвэр эхнээсээ хэрэгжээд эхэллээ.

Эмч, багш нарын тэтгэвэрт гарахдаа авдаг 36 сарын тэтгэмж 15-27 сая төгрөгийг гурав дахин бууруулж, насаараа төрийн үйлчилгээний алба хаасан хүмүүсийн халаас руу гар дүрлээ.

“Шинэ төрлийн татвар нэмэхгүй” гэж амласан ч Засгийн газар малын хөлийн, орон сууцны, авто машины, архи тамхины, бүр цалингийн, ХАОАТ-ын, зуслангийн байшингийн татвар авах шийдвэр санаачлан зүтгүүлж байна.

Энэ бол эрх баригчдын эхний 100 хоногийн ажил.

Зун, намрын 100 хоногт МАН амласнаасаа буцаж, ард олноо мэхэлсэн хууралт, ухралтынх нь захын хэдэн жишээг дурьдахад ийм байна.

Амласнаасаа буцаж, бүр буцсанаасаа буцсан үйлдлийг эрх баригчид хийж байхад Монголын ард түмэн тэднээс юу хүлээх юм бэ гэж асууж байна.

Сум, дүүргийн хурал бол эгэл жирийн иргэн хүний төрд үгээ хүргэх, өөрийнхөө эрх ашгийг хамгаалуулах, нутагтаа эзэн нь байх Үндсэн хуулиар баталгаажсан төрийн анхан шатны байгууллага.

Энэ сонгуулиар амлалтаасаа буцагсад, булгагсад та бид дун тавина. Харин хуурамч хөтөлбөр, худлаа амлалтад нь итгэл алдарч, сэтгэл цөхөрсөн ард олон “Амлалтаа мартагсад ахиад хууртахгүй” гэж хариулж байна.

Энэ удаагийн орон нутгийн сонгууль бол амласан, хийсэн хоёр нь алд дэлэм зөрсөн сайхан дүртэй мэхлэгчдэд өгөх сануулга, сэрүүлэг, даруулга, анхааруулга байх ёстой.

Орон нутгийн сонгуульд мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлднэ гэсэн нөгөө л худал амлалтаа дахин давтах оролдлогыг нь бид хүлээн зөвшөөрөөд суух ёсгүй.

Ардчилсан нам “Төрийн дарамтаас түмнээ өмөөрнө” гэдгээ хариуцлагатайгаар мэдэгдэж байна.

Бид иргэдээ өмөөрөгч, ард олноо хамгаалагч нь байх болно.

Бид ард түмнийхээ халаас, түрийвчний харуул нь байх болно.

Бид иргэн хүний хувийн эрх, эрх чөлөөний манаач нь байх болно.

Бид хохирсон, хууртсан сонгогчдоо эрх баригчдын дарамтаас өмөөрөх эзэд нь байх болно.

Ирээдүйн зээлээр айлгаж байсан нам иргэдийн өнөөдрийн амьжиргаагаар тоглож байна.

Улс орны эрх ашгийн төлөөх Ардчилсан намын шинэчлэл, шийдэл, шийдвэр бүрийг эсэргүүцэн зогсоож, ард түмний эрх ашгийг ч улаандаа гишгэж байгаа Ардын намын ухралтыг бид хамтдаа зогсоох ёстой.

Тиймээс аравдугаар сарын 19-нд мөнгөнд хуурталгүй, Монголоо авч үлдэх, нутагтаа эзэн болохоо баталгаажуулах, амласанд нь биш ажил хийсэнд нь дүн тавих сонголт болно” гээд Ардчилсан намаас нэр дэвшин оролцож байгаа нэр дэвшигчиддээ амжилт хүслээ.



С.Эрдэнэ: Хяналт тавьж, биелэлтийг шаардаж ажиллана

-Сум, дүүргийн бүх төвшинд энэ сонгуульд бид ард түмэнтэйгээ хамт эрх баригчдын амлалт, мөрийн хөтөлбөрт хяналт тавьж, амлалт мөрийн хөтөлбөрийн биелэлтийг шаардаж, хяналт тавьж ажиллах шаардлага тулгараад байна.



С.Одонтуяа: МАН Үндсэн хуулийн гол заалтыг зөрчсөн шийдвэр гаргалаа

-Монгол Ардын нам хүүхдийн мөнгийг алагчлахгүй олгоно гэж сонгуулийн мөрийн хөтөлбөртөө тусгасан. Харин УИХ-ын сонгуулийн дараа 2016 оны есдүгээр сарын 7-ны өдөр УИХ 38 дугаар тогтоол гаргаж, хүүхдийн мөнгийг ялгавартайгаар өгөх тухай тогтоол баталсан. Мөн 2016 оны төсвийн тухай хуулийг батлахдаа Хүний хөгжил санд өөрчлөлт оруулсан байгаа. Хүний хөгжил сангийн тухай хуулийг анх батлахдаа уул уурхайн орлогоос иргэн бүрт тэгш хүртээнэ гэсэн зарчмыг болон Монгол Улсын Үндсэн хуулийн гол заалтыг зөрчиж байна.



Б.Энхбайгаль: МАН-ынхан 4 тэрбум ам.долларын зээлийг буюу гурав дахин их зээлийг илүү өндөр хүүтэйгээр авахаар бэлтгэж байна

-Эрх барьж буй улс төрийн хүчин сонгуулийн маргаашаас эхлээд бүх амлалтуудаасаа ухарч эхэллээ. МАН үзэл нь тодорхойгүй, бодлого нь судалгаагүйгээр амласан амлалтаар дүүрэн байсан нь харгагдаж байна. 1.5 тэрбум ам.долларын зээлийг муулж, өр нэмлээ гэж байсан МАН-ынхан сонгуулиас хэдхэн сарын сараа 4 тэрбум ам.долларын зээлийг буюу гурав дахин их зээлийг илүү өндөр хүүтэйгээр авахаар бэлтгэж байна. Энэ бол эдийн засгийн тусгаар тогтнол, бие даасан байдал алдагдахад хүргэнэ гэсэн үг. Энэ нөхцөлд бид сум орон нутгаасаа эхлээд ардчилалдаа, тусгаар тогтнолоо эзэн болох шаардлага тулгарч байна.



Б.Ган-Очир: Өнөөгийн улс төрийн байдлыг тэнцвэржүүлэхийн тулд орон нутгийн сонгуульд Ардчилсан намд саналаа өгье

-Монголын залуучууд өнөөгийн улс төрийн байдлыг тэнцвэржүүлэхийн тулд орон нутгийн сонгуульд Ардчилсан намд саналаа өгье. Өнөөдрийн Монголын эрх мэдэл дээгүүрээ биш, дунд шатанд, орон нутагт байдаг. Зургаан дүүрэг хөгжинө гэдэг бол өнгөрсөн хугацаанд нийслэлд өөрчилсөн бүх зүйл өөрчлөгдөнө гэсэн үг. Танай аймагт хэрэгцээтэй "Гудамж" төсөл, "Сум" төсөл бүгд дунд шатанд өргөжиж хөгжинө. Тэр төслүүдийг үргэлжлүүлэхгүй гэх юм бол доод шатныхан маань бүгд төр засгийнхаа өмнөөс хүчтэй үг хэлж, шахалт үзүүлнэ гэсэн үг.

ДЭЛХИЙ

Сербийн гаалийнхан 500 кг гурилан бүтээгдэхүүн хураажээ

Сербийн гаалийн албаныхан Болгараас Испани хүрэх олон улсын зорчигч тээврийн автобусанд шалгалт хийж, 500 кг гурилан бүтээгдэхүүнийг хураан авснаа мэдэгдлээ. Болгар, Испани нь хоёулаа Европын холбооны гишүүн орон бөгөөд автобус ЕХ-ны гишүүчлэлгүй Сербийн нутгаар дамжин тээвэр хийхдээ зайлшгүй гаалийн бичиг баримт шаардлагатай аж. Гэвч шаардагдах бичиг баримтгүйгээр нийтдээ 500 кг гурилан бүтээгдэхүүнийг тээвэрлэж явсан тул ийнхүү саатуулж, бүтээгдэхүүнийг хураасан хэмээн Серби мэдэгдээд байна. Түүнчлэн, автобусны жолооч, зорчигчдын хувийн эд хэрэглэл болон хүнсний зүйлс, ногоо зэрэг нь мөн л шаардагдах бичиг баримтгүй байсан гэнэ. Мөн кекс хийх их хэмжээний хайрцаг олдсон бөгөөд 00-ын хэсгээс ч гэсэн хайрцаг олдсон байна. Гурилан бүтээгдэхүүний төрлөөс хамаарч, 137 өөр өөр хэлбэр дүрс бүхий хайрцаг гарч иржээ.

Германы Засгийн газар Дютертээс тайлбар шаардлаа



ХБНГУ-ын Засгийн газар мэдэгдэл гаргаж "Филиппин улсын Ерөнхийлөгч Родриго Дютерте өөрийн явуулж буй хар тамхины эсрэг дайныг нацистууд еврейчүүдийг хоморголон устгасан явдалтай зүйрлэсэн нь байж болшгүй үйлдэл" хэмээн зэмлэн буруушаалаа. Р.Дютерте хэлэхдээ "Гитлер гурван сая еврейчүүдийг устгасан, би ч мөн адил хар тамхичдын эсрэг ийм зүйл хийхэд бэлэн" гэсэн утга бүхий үг хэлсэн юм. Үүнтэй холбогдуулан Германы Гадаад хэргийн яам Филиппиний элчин сайдыг дуудан ирүүлж, дээрх үгэнд тайлбар өгөхийг шаарджээ. Шуугиан тарьсан мэдэгдэл хийдэг гэдгээрээ зард гарсан Дютерте өөрийн 22 жилийн турш даргалж байсан Давао хотод очихдоо цугларсан олонд хандан "Ирээдүй хойч үеийнхээ тусын тулд гурван сая хар тамхичныг дургатайа устга болно. Германд Гитлер байсан бол Филиппинд мөн адил байх болно" гэж хэлээд өөр рүүгээ зааж байжээ. Дютертегийн явуулж буй хар тамхины эсрэг тусгай ажиллагааны явцад 3000 хүн амиа алдсан гэх мэдээлэл байна.



Хиллари Клинтоны дэмжигчид нэмэгдэж,

ТРАМПЫНХ БУУРАВ

...Тэрбумтан эрийн дэмжигчид ийн буурах болсон шалтгаан нь сүүлийн үед дуулиан тариад буй "Miss Universe" тэмцээний ялагчийг зүй бус үгээр доромжилсонтой холбоотой аж...

БДАВАА

Ирэх арваннэгдүгээр сард болох АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтон, Бүгд найрамдах намаас үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп нар нэр дэвшиж байгаа. Трампын хувьд улс төр дэх анхлан сурагцагч гэж

хэлж болох хэдий ч, бизнесийн асар их туршлагатай нэгэн. Харин Хиллари улс төр дэх эмэгтэй хатуу самруудын нэг юм. Амьдралын туршлага үзэл бодол тэс өөр ийм хүмүүс төрийн тэргүүн болон гүйцэтгэх засаглал болох Засгийн газрын тэргүүн гэсэн хоёр том үүргийг гүйцэтгэх АНУ-ын хамгийн "хүчирхэг" хүн болохын төлөө өрсөлдөж байна. Тэгвэл нэр дэвшигчдийн анхны халз мэтгэлцээн өнгөрөгч даваа гарагт болсон юм. 1960 оноос хойш халз мэтгэлцээн зохион байгуулагдах болсон бөгөөд анхны мэтгэлцээнд ялсан эрхэм дараагийн Ерөнхийлөгч болдог гэх яриа ч бий. Тиймээс энэ үед зарим агентлагууд иргэдийн дунд санал асуулга явуулж, хэн ялсныг тус бүртгээ үнэлэхийг оролдсон. Гэхдээ зарим агентлагууд мэтгэлцээнд Хиллариг ялсан гэж үзсэн бол зарим нь нэр дэвшигчид ижил тэгш байсныг онцолж байлаа.

Харин хамгийн сүүлийн үеийн судалгааны үр дүн хэрхэн гарсныг уншигчиддаа сонирхуулъя. Өнгөрөгч сарын 26-ны өдөр орон нутгийн цагаар үдшийн 21.00 цагт эхэлсэн халз мэтгэлцээний дараа "RealClear Politics" сайт санал асуулга явуулж, эцсийн дүнг энэ сарын 1-нд зарлав. Ингэхэд Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтоныг дэмжигчдийн хувь нэмэгдэж, эсрэгээрээ тэрбумтан Доналд Трампын дэмжигчдийн тоо буурчээ. Мэтгэлцээний дараа тэдний

дэмжигчдийн хувь ерөнхийдөө тэнцсэн үзүүлэлттэй байв. Маш бага хувийн зөрүүтэйгээр Хиллари тэргүүлж байсан ч, АНУ-ын улс төрийн мэдээллийн "RealClear Politics" сайтын явуулсан олон нийтийн судалгаагаар АН-ын нэр дэвшигч 43.8 хувь, Трамп 40.9 хувийн дэмжлэг хүлээжээ. Харин улстөрийн жижиг хүчин болох Либерал намын нэр дэвшигч Гари Жонсоныг дэмжигчид 7.3 хувьтай байлаа. Тэрбумтан эрийн дэмжигчид ийн буурах болсон шалтгаан нь сүүлийн үед дуулиан тариад буй "Miss Universe" тэмцээний ялагчийг зүй бус үгээр доромжилсонтой холбоотой аж.

Дэлхий даяар 84 сая орчим хүн үзсэн телевизийн халз мэтгэлцээний дараа Хиллари Клинтоны дэмжигчид Флорида, Невада, Нью Хампшире гэх мужуудад өсчээ. Гэхдээ дэмжигчдийнх нь хувь өссөн гээд ирэх сард болох Ерөнхийлөгчийн сонгуульд ялна гэж ойлговол өрөөсгөл билээ. Ардчилсан нам одоогоор 20 сая орчим хүн амтай, сонгогчдын тоо харьцангуй их буюу өрсөлдөөн өрнөх гол тойрог Флорида муж дахь дэмжигчдийнхээ тоог өсгөх бодлого барьж буй. Харин ингэхийн тулд тэдэнд ердөө хоёр долоо хоногийн хугацаа л үлдээд байна. Тиймээс 2008 болон 2012 оны Ерөнхийлөгчийн сонгуульд Флорида мужид ялагт байгуулсан Барак Обама, Иосеф Байден нар энэ долоо хоногт тус мужид очиж, Хилларигийн сонгуулийн

кампанит ажилд оролцох бололтой.

"Miss Universe" тэмцээний ялагчийг Д.Трамп "гахай" хэмээв

АНУ-ын иргэн болсон учраас энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгуульд саналаа өгнө гэдгийг мэдэж байгаа биз дээ" гэсэн байдаг.

Хиллари Клинтон сонгуулийн кампанит ажилдаа 154 сая ам.доллар зарцуулжээ

Дээр цухас дурьдаад өнгөрсөн "Miss Universe" тэмцээнтэй холбоотой асуудлын энд хөндье. Чухам энэ тэмцээний ялагчийг Доналд Трамп зүй бус үгээр доромжилсон нь илчлэгдсэнээр түүнийг дэмжигчдийн тоо буурсан гэж зарим улс төрийн чиглэлээр дагнан бичдэг сайтууд мэдээлж байгаа. Иймээс тус явдлын талаар сонирхуулъя. 1996 оны "Miss Universe" наадмын ялагч Венесуэлийн гоо бүсгүй Алисия Мачадог эрчимтэй жин нэмэх болсныг нь шүүмжлэн, "Мисс тоорой" гэж хочилсныг халз мэтгэлцээний үеэр Хиллари Клинтон сөхсөн байдаг. Клинтон "Трамп бусдыг дорд үзэж, өөрийгөө дөвийлгөдөг зантай. Тэр эмэгтэйчүүдийг элдвэр хэлж, доромжилдог. Тэгсэн хэрнээ өөрөө гоо сайхны тэмцээнийг зохион байгуулдаг. Трамп Miss Universe тэмцээний ялагч бүсгүйг гахай гэж дуудсан. Түүгээр ч зогсохгүй түүнийг латин америк гаралтай байсан учраас гэрийн үйлчлэгчээ гэж дуудсан баримт бий. Түүнийг гахай гэдэггүй, гэрийн үйлчлэгч ч биш, Алисия Мачадо гэдэг юм. Алисия одоо

Ардчилсан намаас Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Хиллари Клинтон өнгөрөгч есдүгээр сарын кампанитдаа зарцуулсан нийт хөрөнгийнхөө хэмжээг олон нийтэд зарлалаа. Тодруулбал, 154 сая ам.долларыг тэрбээр зарцуулсан байх бөгөөд энэ дүн нь өнгөрсөн хугацаанд байгаагүй их хэмжээ юм. Наймдугаар сард Хиллари 143 сая ам.долларыг зарцуулсан байсан бол Доналд Трампынх 90 сая ам.доллар байв. Ерөнхийлөгчийн сонгууль ирэх арваннэгдүгээр сарын 8-нд болох хэдий ч, санал хураалтын өдөр дохох тусам нэр дэвшигчдийн зарцуулах хөрөнгийн тоо нэмэгдэх бололтой. Үүнээс гадна есдүгээр сард Хилларидад нийтдээ 900 гаруй мянган хүн хандив өргөсөн байна. Үүнийг сурталчилгаа эхэлснээс хойш тооцвол нийтдээ 2.6 сая хүн мөнгө хандивласан байгаа юм. Нөгөөтэйгүүр, Трамп есдүгээр сард сонгуулийн сурталчилгаанд зарцуулсан хөрөнгийнхөө талаархи мэдээллийг нийтэд зарлаагүй байна.

ТАЛ НУТГИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЭЛ

MMINFO АПП
Тал нутгийн өдөр тутмын мэдээ мэдээлэл таны гарт...

TATAFX
PLAY STORE

TATAFX
APP STORE

ШУУРХАЙ МЭДЭЭ

ХҮҮХДИЙН МӨНГИЙГ ЯЛГАВАРТАЙ ОЛГОХ НЬ ХУУЛЬ ЗӨРЧСӨН ҮЙЛДЭЛ

Ж.ОТГОН

УИХ-ын тогтоол, Хүний хөгжил сангийн 2016 оны төсвийн тухай хуулиар хүүхдийн мөнгийг хүүхэд бүрт олгохгүй болсон. Тиймээс үүнийг эсэргүүцэн, Үндсэн хуулийн Цэцэд гомдол гаргасан байна. Энэ талаар УИХ-ын гишүүн асан С.Одонтуяагаас тодрууллаа.

“Хүүхдийн мөнгөний асуудлаар Үндсэн хуулийн Цэцэд өргөдөл гаргаж байгаа гэсэн. Энэ талаар тодруулаач?”

УИХ-ын өнгөрсөн есдүгээр сарын 07-ны өдрийн 38 дугаар тогтоолын холбогдох хэсэг нь Үндсэн хууль зөрчсөн эсэхэд дүгнэлт гаргуулахаар Үндсэн хуулийн цэцэд хандаа байна. УИХ-аас баталсан 38 дугаар тогтоолын дагуу амьжиргааны төвшний 1-10 дугаар бүлэгт орсон айлын хүүхдэд сар бүр 20 мянган төгрөг бэлнээр олгохоор, уг бүлэгт хамаарахгүй бол хүүхдийн мөнгийг хадгаламж хэлбэрээр байршуулж, 2019 оноос бэлнээр авч болохоор заасан. Дээрх тогтоолын дагуу нийт хүүхдийн 60 хувь нь 20 мянган төгрөгийг бэлнээр авах бол үлдэж байгаа 40 хувь нь 2019 оноос бэлнээр авах эрх үүсэх юм. Энэ нь дараах хуулиудыг зөрчиж байгаа. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр бүлгийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэснийг, Хоёрдугаар бүлгийн 14 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэснийг зөрчиж байна. Мөн хоёрдугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Хүнийг үндэс, угсаа, хэл арьсны өнгө, нас хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхан үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэснийг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 1.1-д “Хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй

байх” гэснийг зөрчиж буй. Түүнчлэн “Хүүхдийн эрхийн тухай конвенц”-ын хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Оролцогч улсууд хүүхдийн, түүний эцэг, эх буюу хууль ёсны асран хамгаалагчийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс угсаа, нийгмийн гарал, эд хөрөнгө, эрүүл мэнд, төрсөн болон бусад байдлаас үл шалтгаалан аливаа хэлбэрээр алагчлахгүй” гэснийг зөрчлөө. Энэ нь Монгол Улсын Үндсэн хууль дээдлэх, олон улсын гэрээгээ хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх зарчмыг уландаа гишгэсэн хариуцлагагүй үйлдэл. Монгол Улс 1992 онд Хүүхдийн эрхийн тухай олон улсын конвенцэд нэгдэж орсон. Энэ конвенцоор Монгол Улсын хүлээсэн үүрэг бол хүүхдийн аливаа нэгэн байдлаар ялгаварлан гадуурхахыг хориглосон. УИХ хүүхдийн мөнгийг эцэг, эхийнх нь орлогоос хамаарч олгохоор ангилсан нь иргэдэд орлогоор нь ялгаварласан хэрэг боллоо. Олон улсын өмнө хүлээсэн гэрээ, Үндсэн хуулийн зарчмаасаа ухарлаа. Засгийн газар мөнгөгүй байж болно. Гэхдээ нийгмийн үнэт зүйл болсон иргэдийнхээ халаас руу гараа дүрж, хүүхдийн мөнгө,

ахмадын тэтгэмжийг багасгаж байгаа нь увайгүй үйлдэл гэж үзэж байна.

“Хүүхдийн мөнгийг нийт хүүхдийн 60 хувьд олгож, үлдсэн 40 хувийнх нь мөнгийг 2019 онд өгнө гэж байгаа. Тиймээс ч үүнийгээ тэгш байдлыг хангаж байгаа хэмээн тайлбарлаад байгаа шүү дээ?”

Төсөв байхгүй учраас энэ хуулийг хэрэгжүүлэхгүй, байх юм бол хэрэгжүүлнэ гэдэг зүйл хуульд байдаггүй. Үүнийг УИХ, Засгийн газрын гишүүд бүгд л мэдэж байгаа. Хамгийн гол нь энэ бол алагчлал. 2016, 2017, 2018 онд уул уурхайн орлогоос иргэдэд тэгш хүртээх ёстой байтал алагчилж хүртээж байна. Нэг хэсэг нь 2016 онд авч байхад нөгөө хэсэг нь 2019 онд авна гэдэг бол алагчлал. Эсвэл бүгдэд нь тэгш хүртээ, эсвэл бүгдэд нь өгөхөө боль. Ялгаварлал, алагчлал хэрэггүй. Иргэдийн амьжиргааг судалж, арван бүлэгт хувааж байна. Ийм судалгаа хийж болохоос биш судалгаагаараа иргэдийг алагчилж, тэгш хүртээх ёстой мөнгийг заримд нь олгож болохгүй. Судалгааг нь үзэхээр хүүхдийн ээж аавын боловсрол, монгол гэрийн ханын тоо, эд хогшлын тоо, цалинг хүртэл заасан. Иргэдээ ялгаварласан

энэ судалгааг баримталж хуулийг хэрэглэж байгаа нь болохгүй.

“Ахмадуудад ч ялгавартай мөнгө олгохоор болоод байгаа. “Насны хишиг” нэртэй хууль санаачилж батлуулна гэж байна. Энэ талаар та ямар байр суурьтай байгаа вэ?”

Хамтын тэтгэврийн тухай хуулийг санаачилж батлуулсан хүнийх нь нэг би. Энэ хууль хоёр үндсэн зарчмыг баталгаажуулсан. Одоо амьдарч байгаа манай ахмадууд социализмын бүтээн байгуулалтад зүтгээд, өөртөө хадгаламжгүй, эд хогшилгүй байгаа. Ийм учраас бүтээн байгуулалтынхаа үр шимийг нь хүртэх боломжийг бүрдүүлж ач санах шаардлагатай. Хоёрдугаарт, гэр бүлийг бат бөх байлгахад энэ хууль маш чухал. Өөрөөр хэлбэл, гэр бүл 15-аас дээш жил тогтвортой амьдарсан байх ёстой гэх мэт шаардлага тавьсан байсан. Гэтэл одоо биеэ ортолж байгаад 70 нас хүрсэн ч насны хишиг авна гэж байна. Дахиад насаар нь ялгаварласан хууль болчихлоо. Өчигдөр /өнгөрсөн пүрэв гарагт/ Эрүүл мэндийн яам “Ахмад настныг насаар нь ялгаварлахыг зогсооё” гэсэн аян өрнүүлж байгаа. Би үүнийг нь дэмжиж байгаа.

Төгрөгөөр гүйлгээ хийгээгүй газруудад арга ХЭМЖЭЭ АВЧЭЭ

Үндэсний мөнгөн тэмдэгтээр төлбөр тооцоо явуулж байгаа эсэхэд Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкны хамтарсан ажлын хэсгүүд хэсэгчилсэн шалгалтыг зарим аж ахуйн нэгжүүдэд хийжээ. Шалгалтад нэр бүхий зочид буудал, бүрэн дунд сургууль, үнэт эдлэлийн дэлгүүрүүдийг хамруулахад төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр хийгээгүй, бараа бүтээгдэхүүнийхээ үнийг гадаад валютаар илэрхийлсэн, Монголбанкны зөвшөөрөлгүйгээр тооцооны нэгжээр илэрхийлсэн, цалин хөлсийг төгрөгөөр олгоогүй зэрэг зөрчлүүд илэрсэн байна. Илэрсэн зөрчлүүдийг арилгуулахаар Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн дагуу шаардлага тавьж, тухайн үйл ажиллагаанаас олсон орлогыг хурааж улсын орлого болгох, улсын байцаагчийн албан шаардлагаар үүрэг даалгавар өгч, мөн таван аж ахуйн нэгжид захиргааны хариуцлага ногдуулж, торгуулийн арга хэмжээ авсан байна.

PHOTO NEWS



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

Жил бүрийн аравдугаар сарын 02-ны өдөр С.Зориг агсны хөшөөнд хүндэтгэл үзүүлдэг уламжлал тогтсоор 18 жил болжээ. Ойн өдрийг тохиолдуулан өчигдөр төр нийгмийн зүтгэлтэн С.Зоригийн ах дүү, гэр бүл, найз нөхөд, болоод төрийн өндөрлөгүүд хөшөөнд нь цэцэг өргөж хүндэтгэл үзүүлсэн юм. Цэцэг өргөх ёслолд түүний гэр бүл, журлын нөхдөөс нь гадна Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, С.Зориг агсны ах С.Баяр, дүү С.Оюун зэрэг олон хүлүүс оролцлоо.

Нийслэл “Хэвлэл мэдээллийн төв”-тэй боллоо

Нийслэлийн Засаг дарга С.Батболдын санаачилгаар ЗДП-ын дэргэд “Хэвлэл мэдээллийн төв” байгуулж, нээлтээ хийлээ. Иргэдийн нүд, чих болдог хэвлэл мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж, нийслэлийн ЗДП болон харьяа байгууллагуудын мэдээллийг нэг дор төвлөрүүлж, нэг шугамаар хүргэх зорилгоор энэхүү төвийг байгуулсан байна. Нээлтийн үеэр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Батболд “Төр засгийг иргэдтэй холбож, иргэдийн төлөө гарсан шийдвэрийг хүргэдэг хүмүүс нь хэвлэл мэдээллийн ажилтнууд та бүхэн юм. Нийслэлийн Засаг даргын хувьд би ирэх дөрвөн жилд нээлттэй ажиллаж, гаргасан шийдвэр, мэдээллийг энэ төвөөр дамжуулан иргэддээ хүргэх болно. Өөрөөр хэлбэл, энэ төвөөр дамжин иргэд мэдээ мэдээллийг цаг алдалгүй, шуурхай авах боломж бүрдэнэ гэсэн

үг. Энэ төв зөвхөн нийслэлийн төр захиргааны байгууллагын мэдээллийг нэгтгэхээс гадна та бүхний ажлын байр байх юм.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа бүх хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд ирж, мэдээлэл авах, иргэдтэй уулзалт хийх, хэвлэлийн бага хурал зохион байгуулах боломжтой. Энэ бүхнийг та бүхэн хэн нэг даргаас зөвшөөрөл авахгүйгээр хийх боломжийг олгосон байгаа. НИТХ-ын хуралдаан, Засаг даргын зөвлөлийн хуралдаан болон Хангарьд ордонд болж байгаа бүх хурлыг шууд хүлээн авах боломж бүрдсэн байгааг онцолж. Мөн өндөр хурдны интернэтэд холбогдсон учраас иргэдэд мэдээллийг шуурхай хүргэх нөхцөл бүрдсэн. Ингээд НЗДП-ын дэргэдэх “Хэвлэл мэдээллийн төв” албан ёсоор нээгдсэнийг мэдэгдье” гэсэн юм.

Нийслэлийн 57 хувь нь нянгийн бохирдолд дарагджээ

Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгээс гаргасан орчны нөлөөлөл иргэдийн эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж буй судалгааны тайлангаа өнгөрсөн долоо хоногт танилцуулсан юм. Энэ судалгаанд дурьдсаанаар нийслэлийн суурьшлын бүсийн 57 хувь нь нянгийн бохирдолд дарагджээ. Бохирдлын эх үүсвэрт дараах шалтгаануудыг нэрлэж байна. Нийслэлд жилд дунджаар

210-260 мянган тонн хаягдал үүсдэг. Бохир усны цэвэрлэх байгууламжаар хоногт 190 мянган м.куб бохир ус цэвэрлэгдэн хаягддаг. Нийслэлийн гэр хорооллын өрхийн 90 гаруй хувь нь энгийн нүхэн жорлон ашигладаг зэргээс хөрсний бохирдлын хэмжээ жил ирэх тусам өссөөр байгааг дурьджээ. Тиймээс цаашид хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй технологи судалж, турших, орчны

бохирдлоос үүсэх өвчлөлийн судалгааг нарийвчлан явуулж үнэлгээ хийх, хүрээлэн буй орчны бохирдлоос сэргийлэх арга замын талаар сургалт явуулах. Мөн төв рүү чиглэсэн шилжин суурьшилтыг багасгаж, бодлого боловсруулах шаардлага бийг дурьджээ. Нэн тэргүүнд эрх зүйн зохицуулалт, төлөвлөлтийг боловсронгуй болгох хэрэгтэй гэдгийг уг тайланд тусгасан байна.

Оюутнууд хөнгөлөлттэй үнээр зорчиж эхлэв

Оюутнууд өнгөрсөн есдүгээр сарын 27-ноос нийтийн тээврийн автобусаар хөнгөлөлттэй үнээр зорчиж эхэлжээ. Тодруулбал, 250 төгрөгөөр зорчих боломж үүсч байгаа аж. Смарт картыг оюутнууд сургуулийнхаа Оюутны холбоогоор дамжуулан 3600 төгрөг захиалснаар авч байгаа юм. Гэхдээ Нийтийн тээврийн зохицуулах газраас нэг оюутны зорчих эрхийг сард 22 удаа үйлчлүүлэх эрхтэй байхаар хязгаарлажээ. Өнгөрсөн жил оюутны автобусаар зорчих сарын үйлчилгээний эрхийг 40 гаруй удаа байхаар зохицуулж шийдвэрлэж өгсөн бол өнөө жил хоёр дахин буурсан юм байна.

“Хэпсинат” эмийг 150 ам.доллараар худалдаалж байна

С вирусны эсрэг эм “Харвони”-той ерөнхий нэршлийн эм болох “Хэпсинат” эмийг нэг хайрцгийг нь 150 ам.доллараар худалдаалж байгаа. “Хэпсинат” эм нь “Харвони”-той ижил үйлчилгээтэй, Энэтхэг улсад үйлдвэрлэсэн, 98 хувийн үр дүнтэй гэдгийг мэргэжилтнүүд онцолж байгаа. Тус эмийг болон “Харвони” эмийг худалдаалж буй нэр бүхий эмийн сангуудаар борлуулж эхэлжээ. Тус эмийг “Харвони”-той адил эмчийн жороор 3-6 хайрцаг уух ёстой аж. Харин зургаан сар уух шаардлагатай иргэдэд зургаа дахь хайрцгийг үнэ төлбөргүй олгохоор зохицуулжээ. Учир нь зургаан сар уух шаардлагатай иргэдийн хувьд олон шинжилгээ өгч, эм авах тусам санхүүгийн хүндрэлтэй тулдаг тул нийм зохицуулалт хийсэн байна. Ер нь “Харвони”-оос гадна ерөнхий нэршлийн дөрвөн эм байдаг аж. Харин Монгол Улс хоёр эмийг оруулж ирээд буй нь энэ ажээ.



Намрын өгнө



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 4
Шөнө -3

Нөгөөдөр
Өдөр 1
Шөнө -6

Өдрийн зурхай

Намрын адаг шар нохой сарын Нэг цагаан мэнгэтэй Шар морь өдөр. Сумъяа гараг

Үс засуулбал: Хэл ам, хэрүүл тэмцэл ирнэ

Наран ургах, шингэх: 07:04 - 18:38



Өдрийн өгнө: Тухайн өдөр бар, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр архи уух, талхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба угаал үйлдэх, тангараг тавих, гэр бүрхэд сайн. Хэрүүл тэлцэл хийх, хүүхэд холд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод баруун ураги төрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиролжгүй.

ОДДЫН АМЬДРАЛ



Б.ДАВАА

Мадонна САНАЛАА ӨГӨХДӨӨ НҮЦГЭН ирэхийг уриалжээ

Дуучин Мадонна нүцгэн зургаа сошиал хуудаснаа нийтэлж, ирэх арваннэгдүгээр сарын 8-нд болох Ерөнхийлөгчийн сонгуульд нүцгэн саналаа өгөхийг уриалжээ. Түүнээс өмнө Кэйти Перри ч нүцгэн саналаа өгөхийг уриалсан бичлэгийг өөрийн хуудастаа байрлуулаад байсан юм. Тэгвэл 58 настай дуучин Мадонна ч цээж нүцгэн зургаа инстаграм хуудастаа нийтэлсэн байв. Тэрбээр “Би ч гэсэн Кэйти Перритэй адил нүцгэн саналаа өгнө” гэх тайлбарыг зүүсэн байсан бөгөөд бүр Ардчилсан намаас нэр дэвшигч Хиллари Клинтонг дэмжих гэдгээ илэрхийлжээ. Харин одоогоор дуучин зургаа устгасан аж.



Бидэнд тохиолдсон



Nandin-Erdene Nandia



Б. Дэлгэрдалай



Цасан шуурга болох анхааруулга мэдээ харсан чинь санаанд ордог байна шүү. Хэдэн жилийн өмнө Онцгой байдлын албанаас мэдээ авдаг байсан юм. Нэг орой жаахан ойлгомжгүй мэдээ ирлээ. “Тэр аймаг тэр сумын тийм газар өвөлжиж байсан иргэн У малд явж байгаад шуурганд төөрсөн тул Онцгой байдлын алба хаагчид таван хүний бүрэлдэхүүнтэй нэг техник хэрэгсэлтэйгээр хайж, маргааш өдрийн үдэд тэр газар өвөлжиж байсан тэднийг гэдэг айлсаа эсэн мэнд оллоо”. Тэгэхээр нь утсаар залгаад тэгээд энэ чинь шуурганд уруудаад айлд очоод амьд гарчихсан байсан юм бол нэг их ач холбогдолтой мэдээ биш юм биш үү гэсэн чинь “Наадах чинь айлын эхнэр эзгүйчилж хоносон байна билээ. Баахан бензин тос үрүүлээд, мэдээндээ оруулчих авгайдаа алуулаг” гэж авдаг байгаа.

ТЭНГИС



“Deepwater Horizon” нь найруулагч Peter Berg-н найруулсан, Deepwater Horizon хэмээх өрмийн цамхгийн сүйрлийн бодит түүхээс сэдэвлэсэн бүтээл юм.



Риогийн олимпис мөнгөн медаль хүртэж эх орныхоо нэрийг дэлхийн тавцанд гаргасан жүдоч Д.Сумъяагийн амьдралаас сэдэвлэн бүтээв.



Жэкоб хүүд нэгэн захиа ирсний дагуу нууцлаг арал дээр очно. Тэнд төрөл бүрийн өвөрмөц чадвартай хүүхдүүд амьдардаг Хадатгай Перегриний өвөрмөц хүүхдийн ордон байлаа.

УДАХГҮЙ ТЭНГИСИЙН ДЭЛГЭЦНЭЭ




Гарах хугацаа 2016.10.07



Гарах хугацаа 2016.10.13



Гарах хугацаа 2016.10.14



Гарах хугацаа 2016.10.20



Гарах хугацаа 2016.10.28